



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/583

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж, 2022 онд ажил хөдөлмөрөөрөө тэргүүлж, “Аварга малчин”-аар шалгарсан малчин өрхүүдийг шагнахад зориулж, 3,059,000 (Гурван сая тавин есөн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231011457

Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дугаар сарын 17 өдрийн 11/582
дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Аварга малчин медаль	161	10,500	1,690,500
2	Үнэмлэх, Хавтас	161	2,000	322,000
3	Хайрцаг	161	6,500	1,046,500
	Дүн			3,059,000